



ХОВД АЙМАГ  
ХОВД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 457

Дунд ус

Газрын дуудлага худалдаа зохион байгуулах тухай

Газрын тухай Монгол Улсын хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 7/07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Тус сумын Дунд ус багийн төвд 2000 м<sup>2</sup> газрыг “Сүм барих зориулалт”-аар, Баянбулаг багийн нутаг дэвсгэрт авто зам дагуу 1000 м<sup>2</sup> газрыг “Худалдаа, үйлчилгээ эрхлэх зориулалт”-аар, Дунд ус багийн төвд 600 м<sup>2</sup> газрыг “Банк, санхүүгийн байгууллагын байр барих зориулалт”-аар тус тус 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийн дуудлага худалдааг 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.


2. Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, анхны үнийг хавсралтаар баталсугай

3. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаанд оролцох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох материалыг хуулийн дагуу бүрдүүлэх, хүлээн авах, мэдээллийн хэрэгслээр зарлах, бэлтгэх ажлыг хангаж ажиллахыг Газрын даамал /Х.Жанар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ЕРБОЛАТ



Сумын Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын  
25-ны өдрийн 17-тоот захирамжийн хавсралт



Дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр зарласан  
газрын байршил, хэмжээ, анхны үнэ

№	Газрын байршил	Газар эзэмших зориулалт	Код	Газар талбайн хэмжээ /м <sup>2</sup> /	Газар эзэмших хугацаа	Дуудлага худалдааны анхны үнэ /төгрөг/
1	Дунд ус баг	Шашин сүм барих	2109	2000	15	1600000
2	Баянбулаг баг /авто зам дагуу/	Худалдаа үйлчилгээ эрхлэх	2111	1000	15	800000
3	Дунд ус баг	Банк, санхүүгийн байгууллага	2106	600	15	480000